



ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

# “АЛТАН БУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ТАТВАРЫН ТУСГАЙ ДЭГЛЭМ



# ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ТАТВАРЫН ХАРИЛЦАА

Татварын ерөнхий хууль

Татварыг зөвхөн улсын их хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй

/ТЕХ-ийн 4.1/

Чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг Чөлөөт бүсийн тухай хуулиар тогтоож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг татварын холбогдох хуулиар зохицуулах.

/ТЕХ-ийн 4.1.2/



# АЛБАН ТАТВАР НОГДОХ БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулахад нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувь хэмжээгээр ногдуулах;

/ЧБтХ-ийн 16.1.3./

Энэ хуулийн 16.1.4-т зааснаас бусад барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон бусад татварыг холбогдох хуулийн дагуу ногдуулах;

/ЧБтХ-ийн 16.1.5./

/зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг/



# Албан татвар ногдуулахгүй бараа ажил үйлчилгээ

Хилийн чанадаас чөлөөт бүсэд импортолсон бараанд импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй;

/ЧБТХ-ийн 16.1.1./

Импортын гаалийн, онцгой болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг чөлөөт бүсэд оруулахад татвар ногдуулахгүй бөгөөд гаалийн нутаг дэвсгэрт тухайн татварыг төлсөн баримтыг үндэслэн бусад татвараас хасалт хийж буцаан олгох;

/ЧБТХ-ийн 16.1.2./

Барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад татвар ногдуулахгүй;

/ЧБТХ-ийн 16.1.6./

Чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй.

/ЧБТХ-ийн 16.1.7./



# АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ

Дараах орлогод албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:

- Чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;

/ААНОАТТХ-ийн 22.5.7/

- Чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;

/ААНОАТТХ-ийн 22.5.8./



# АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ

- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.4-т зааснаас гадна зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх; /ЧБтХ-ийн 16.1.4./

- /ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ 38.1.4.зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл;/
- 3.1.3.“гаалийн нутаг дэвсгэр” гэж Гаалийн тухай хуулийн 4.1-д заасныг;
- ГтХ-ийн 4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрийг гаалийн нутаг дэвсгэр гэж үзнэ.
- НӨАТтХ-ийн 13.1.27. чөлөөт бүсэд зорчигчийн худалдаж авсан гурван сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараа.

- **Чөлөөт бүсэд баригдаж бүртгэгдсэн барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас бүрэн чөлөөлөх.**

/ЧБтХ-ийн 16.5.2./